



Хэвлэлийн мэдээ
2018 оны 5-р сарын 9

Холбоо барих
+976 99098904

Монгол Улс, АНУ-ын хооронд байгуулсан Ил тод байдлын хэлэлцээрийн тухай мэдээлэл олгох семинар зохион байгууллаа

УЛААНБААТАР, Монгол улс - 2018 оны 5-р сарын 9-ний өдөр Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол), Монгол дахь АНУ-ын Элчин Сайдын Яам хамтран “Монгол Улс, АНУ хоорондын Ил тод байдлын хэлэлцээрийн тухай” мэдээлэл олгох семинарыг Стар Комьюнити төвд зохион байгууллаа.

Семинарт хувийн хэвшил, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрын төлөөлөл, АмЧам Монголын гишүүн компаниуд болон АНУ-ын ЭСЯ-ны холбогдох хүмүүс оролцлоо. Семинарын үеэр Ил тод байдлын хэлэлцээрийн талаар АНУ-ын ЭСЯ-наас илтгэл тавьж оролцогчдын дунд хэлэлцүүлсэн бөгөөд Монгол улсад хууль боловсруулах үйл явцад ил тод байдлыг хэрхэн хангаж буй тухай тэр дундаа Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэргийн тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийн үндэслэл, хэрэгжилтийн талаар Mahoney Liotta, Melville & Erdenedalai болон Minter Ellison зэрэг хуулийн фирмүүд сонирхолтой илтгэл тавьж оролцогчдын асуултад хариуллаа.

АНУ-ын ЭСЯ-ны Хэргийг түр хамаарагч ноён Мануэл Микаллер семинарыг нээж хэлсэн үгэндээ Ил тод байдлын хэлэлцээр, түүний хэрэгжилтийн ач холбогдлыг онцолж “Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч талуудад хамааралтай шинэ хууль тогтоомжийг батлах үйл явцад ил тод байдлыг институтчилэх шаардлагатай байна. Өнөөдөр анх удаа Ил тод байдлын хэлэлцээр, түүнтэй холбоотой тодорхой хуулиуд, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар практик семинарыг бизнесийн төлөөлөлтэй ийнхүү хамтран зохион байгуулж байна” гэв.

АмЧамын ТУЗ-ийн дарга Стив Поттер нээлтийн үгэндээ: “Ил тод байдлын хэлэлцээрийн хэрэгжилтийг АмЧам чухачлан дэмждэг бөгөөд тус хэлэлцээрийн хэрэгжилт нь хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаанд онцгой ач холбогдолтойг АмЧамын “Өсөлтөд Хүрэх Зам” бодлогын баримт бичигт тодорхой тусгасан байдаг” хэмээн онцлон тэмдэглэв.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм.

АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.